ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

## ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ

**АУДИТЫН КОД: ТӨА-2026/002/-НА-СТА-ТТЗ**

**ТӨВ АЙМГИЙН ДЭЛГЭРХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН**

Зуунмод 2026 он

Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал
Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn
Аудитын менежер О.Амаржаргал
Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn
Аудитор С.Намшир
Утас: 70273204 Цахим хаяг: namshirs@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2026.03.24 № 01/271

танай ____________-ны № ________________-т

ТӨВ АЙМГИЙН ДЭЛГЭРХААН СУМЫН
ЗАСАГ ДАРГА М.АНХБААТАР ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант оны үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно. Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна.

Тайлант онд сумынхаа эдийн засаг, нийгмийн хөгжлийг тогтвортой ахиулах, оновчтой бодлого, зохицуулалтаар хангах замаар сумынхаа хөгжилд дэмжлэг үзүүлэх зорилго тавьж ажиллажээ. Сумын сургуулийн түүхт 100 жилийн ойг тохиолдуулан 250,000.0 мянган төгрөгийн төсөвтэй ахлах сургуулийн их засварын ажил хийгдсэн байна.

**Аудитын гол асуудал**

Дэлгэрхаан сумын Эрүүл мэндийн төвийн их засварын ажлыг Япон улсын хөрөнгө оруулалт болон аймгийн хөрөнгө оруулалтаар нийт 612,000.0 мянган төгрөгийг батлуулж, ажлыг эхлүүлсэн. Мөн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 200,000.0 мянган төгрөгөөр үүрэн холбооны оператор “Скайтел”-ийн сүлжээг нэвтрүүлсэн байна.

·4126020667

**Бусад асуудлын хэсэг**

Сумын 2025 оны Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр 17 зорилт, 79 арга хэмжээтэй хэрэгжилт 93,9 хувийн үр дүнтэй дүгнэгдсэн, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 11 зорилт, 29 арга хэмжээтэй хэрэгжилт 89,3 хувьтай, төрийн албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөний хэрэгжилт 22 зорилт, 71 арга хэмжээтэй хэрэгжилт 87,9 хувьтай тус тус дүгнэгдсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ХИШИГЖАРГАЛ

## 2. Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /мянган төгрөгөөр/

| Дансны нэр, төрөл | Тодруулга | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | | **735,641.51** | **782,800.5** |
| **1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **3а, 3б** | **232,690.56** | **238,017.91** |
| **1.1.3 АВЛАГА** | **5а, 5б, 6а, 6б** | **400,817.61** | **431,588.87** |
| **1.1.5 БАРАА МАТЕРИАЛ** | **8а, 8б, 8в** | **102,133.34** | **113,193.73** |
| **1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | | **3,215,800.71** | **3,170,370.11** |
| **1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **12а, 12б, 12в** | **3,215,800.71** | **3,170,370.11** |
| 1.2.2.02 Биет хөрөнгө | | 3,075,033.31 | 3,029,640.22 |
| 1.2.2.03 Биет бус хөрөнгө | 13 | 140,767.4 | 140,729.9 |
| **1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2** | | **3,951,442.21** | **3,953,170.61** |
| **2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР** | | **71,239.3** | **160,128.06** |
| **2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | | **71,239.3** | **160,128.06** |
| 2.1.1.03 Өглөг | | 71,239.3 | 160,128.06 |
| **2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | | **3,880,202.91** | **3,793,042.55** |
| 2.2.1 Засгийн газрын хувь оролцоо | | 3,880,202.91 | 3,793,042.55 |
| 2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал | | 579,464.77 | 579,464.77 |
| 2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн | | 2,989,722.77 | 2,902,562.4 |
| 2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | | 311,015.38 | 311,015.38 |
| **2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | | **3,951,442.21** | **3,953,170.61** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /мянган төгрөгөөр/

| Дансны нэр, төрөл | Тодруулга | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН** | | **2,759,251.55** | **1,821,012.87** |
| **1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО** | | **587,313.52** | **423,579.15** |
| **1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1а, 1б** | **217,649.68** | **1,397,433.72** |
| **1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **2а, 2б** | **2,226,386.73** | **1,978,061.43** |
| **1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ** | | **1,820,383.63** | **1,683,004.66** |
| **1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | **1,784,330.52** | **1,666,978.51** |
| 1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | | 601,038.64 | 708,413.88 |
| 1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | | 80,761.87 | 96,724.12 |

| | | | |
|---|---|---|---|
| 1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | | 497,964.98 | 489,080.13 |
| 1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал | | 45,829.86 | 24,277.25 |
| 1.1.2.01.1.05 Нормативд зардал | | 54,148.25 | 42,145.25 |
| 1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал | | 29,750.00 | 31,905.20 |
| 1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал | | 8,718.00 | 6,305.30 |
| 1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | | 133,603.97 | 15,832.36 |
| 1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал | | 332,514.96 | 252,295.03 |
| **1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | **36,053.10** | **16,026.15** |
| **1.1.2.02 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | | **406,003.10** | **295,056.78** |
| **1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | | **532,864.83** | **-157,048.57** |
| **1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | | **0.0** | **839.10** |
| **1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)** | | **0.0** | **-839.10** |
| **1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН** | | **532,864.83** | **-157,887.66** |

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /мянган төгрөгөөр/

| Дансны нэр, төрөл | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---|---|---|
| **1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН** | **2,620,577.38** | **1,800,257** |
| **1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО** | **587,313.52** | **425,111.15** |
| **1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **86,434.34** | **1,375,145.85** |
| **1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА бa ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **2,007,318.11** | **1,466,037.15** |
| **1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,007,318.11** | **1,466,037.15** |
| **1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,971,564.47** | **1,449,910.37** |
| 1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 596,249.42 | 708,413.88 |
| 1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 84,523.18 | 96,724.12 |
| 1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 497,964.98 | 484,862.93 |
| 1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал | 40,700.91 | 26,207.47 |
| 1.1.1.2.01.1.05 Нормативд зардал | 63,795.47 | 39,597.72 |
| 1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал | 23,920 | 21,293.3 |
| 1.1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал | 8,718 | 5,795.3 |
| 1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 182,708.13 | 14,891.1 |
| 1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал | 472,984.38 | 52,124.55 |
| **1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **35,753.64** | **16,126.79** |
| **1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **613,259.26** | **334,219.84** |
| **1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН** | **458,057.3** | **297,990.6** |

| | | |
|---|---|---|
| **1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **458,057.3** | **297,990.6** |
| 1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр | 458,057.3 | 297,990.6 |
| **1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **-458,057.3** | **-297,990.6** |
| **1.1.3.2 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ** | **0.0** | **30,901.9** |
| **1.1.3 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН** | **0.0** | **-30,901.9** |
| **1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **155,201.96** | **5,327.34** |
| 1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 77,488.6 | 232,690.56 |
| 1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 232,690.56 | 238,017.91 |

### 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /мянган төгрөгөөр/

| Дансны нэр, төрөл | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Нийт цэвэр хөрөнгө / өмч |
|---|---|---|
| **1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | **2,719,481.32** | **2,719,481.32** |
| 1.1.1.1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 627,856.77 | 627,856.77 |
| 1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 3,347,338.09 | 3,347,338.09 |
| 1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн | 532,864.83 | 532,864.83 |
| **1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | **3,880,202.91** | **3,880,202.91** |
| **1.1.1 2025 оны 1-р сарын 1-ний үлдэгдэл** | **3,880,202.91** | **3,880,202.91** |
| 1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 70,727.3 | 70,727.3 |
| 1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 3,950,930.21 | 3,950,930.21 |
| 1.7 Тайлант үеийн үр дүн | -157,887.66 | -157,887.66 |
| **1 2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | **3,793,042.55** | **3,793,042.55** |

### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /мянган төгрөгөөр/

| Дансны код | Дансны нэр, төрөл | Төлөвлөгөө-хамаарах устгалын дараах | Гүйцэтгэл-хамаарах устгалын дараах | 12. Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | 3.1.01.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | 1,903,698.50 | 1,667,574.35 | 236,124.15 | 87.6 |
| 11 | 3.1.01.1.1 Татварын орлого | 605,696.10 | 425,111.15 | 180,584.95 | 70.2 |
| 12 | 3.1.01.1.2 Татварын бус орлого | 1,298,002.40 | 1,242,463.20 | 55,539.20 | 95.7 |
| II | 3.1.01.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,951,259.2 | 1,564,571.64 | 386,687.6 | 80.2 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210 | 3.1.01.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,465,730.10 | 1,299,226.77 | 166,503.33 | 88.6 |
| 2101 | 3.1.01.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 663,751.10 | 636,838.89 | 26,912.21 | 95.9 |
| 2102 | 3.1.01.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 87,810.60 | 87,810.60 | - | 100.0 |
| 2103 | 3.1.01.2.1.1.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 486,644.50 | 484,537.35 | 2,107.15 | 99.6 |
| 2104 | 3.1.01.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал | 27,175.00 | 24,879.22 | 2,295.78 | 91.6 |
| 2105 | 3.1.01.2.1.1.5 Нормативд зардал | 1,190.00 | 1,190.00 | - | 100.0 |
| 2106 | 3.1.01.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал | 21,413.30 | 21,293.30 | 120.00 | 99.4 |
| 2107 | 3.1.01.2.1.1.7 Томилолт, зочны зардал | 6,375.30 | 5,795.30 | 580.00 | 90.9 |
| 2108 | 3.1.01.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 22,456.80 | 14,757.57 | 7,699.23 | 65.7 |
| 2109 | 3.1.01.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал | 148,913.50 | 22,124.55 | 126,788.95 | 14.9 |
| 213 | 3.1.01.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 28,929.6 | 16,452.36 | 12,477.2 | 56.8 |
| 22 | 3.1.01.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 385,529.10 | 217,990.60 | 167,538.50 | 56.5 |
| 23 | 3.1.01.2.3 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 100,000.00 | 30,901.90 | 69,098.10 | 30.9 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 217,105.26 | - | - |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 207,470.06 | - | - |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /мянган төгрөгөөр/

| Дансны код | Дансны нэр, төрөл | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **1.1.1.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН** | **563,628.02** | **194,454.67** |
| **12** | **1.1.1.1.1 ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **563,628.02** | **194,454.67** |
| 350013 | 1.1.1.1.1.1.1.1.3 ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 5,320.00 | 83,736.86 |
| 350014 | 1.1.1.1.1.1.1.1.4 Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 558,308.02 | 110,717.82 |
| **II** | **1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **563,628.02** | **191,816.76** |
| **21** | **1.1.1.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ** | **563,628.02** | **111,816.76** |
| **210** | **1.1.1.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **435,184.98** | **111,816.76** |
| 2101 | 1.1.1.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 59,144.28 | 71,574.99 |

| | | | |
|---|---|---|---|
| 2102 | 1.1.1.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 7,507.28 | 8,913.52 |
| 2104 | 1.1.1.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал | 5,230.01 | 1,328.25 |
| 2108 | 1.1.1.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж | 902.11 | - |
| 2109 | 1.1.1.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал | 361,721.30 | 30,000.00 |
| 2132 | 1.1.1.2.1.1.7 Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны нэмэгдэл | 14,892.27 | - |
| 2134 | 1.1.1.2.1.1.10 Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох | 113,550.76 | - |
| **22** | **1.1.1.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **80,000.00** |

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсант ай холбоотой | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс Залруулсан | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Засаг дарга | 1 | 325.6 | | | 1 | 325.6 | 1 | 325.6 |
| ЗДТГ | 1 | 5,428.4 | | | 1 | 5,428.4 | 1 | 5,428.4 |
| ИТХ | 1 | 467.5 | | | 1 | 467.5 | 1 | 467.5 |
| Соёлын төв | 2 | 4,531.1 | | | 1 | 4,531.1 | 2 | 4,531.1 |
| ЭЭС | 1 | 466.7 | 1 | 466.7 | | | 1 | 466.7 |
| **Дүн** | **6** | **11,219.3** | **1** | **466.7** | **4** | **10,752.6** | **6** | **11,219.3** |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Засаг дарга | 1 | 161,648.8 | | | 1 | 161,648.8 | | |
| ИТХ | 2 | 1,642.0 | 1 | 457.0 | 1 | 1,185.0 | | |
| ЗДТГ | 2 | 72,320.5 | 1 | 569.2 | | | 1 | 71,751.3 |
| ХХС | 2 | 451,685.9 | | | 1 | 326,747.8 | 1 | 124,938.1 |
| Соёлын төв | 1 | 4,000.0 | | | 1 | 4,000.0 | | |
| **Дүн** | **8** | **691,297.2** | **2** | **1,026.2** | **4** | **493,581.6** | **2** | **196,689.4** |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | | | |
| Засаг дарга | 1 | - | | | | | 1 | - | | |
| ЗДТГ | 1 | - | | | | | 1 | - | | |
| ЭЭС | 1 | - | | | | | 1 | - | | |
| **Дүн** | **3** | **-** | | | | | **3** | **-** | | |

**Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

| Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | Өөрчлөлтгүй | Өөрчлөлттэй | | |
| | | санал дүгнэлт гаргах | Түүвэрт хамрагдах | Аудит хийгээгүй | | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| Төсвийн шууд захирагч | 3 | 1 | 2 | | 1 | | | |
| Орон нутгийн тусгай сан | 4 | | 4 | | | | | |
| Төсвийн төвлөрүүлэн захирагч | 1 | 1 | | | 1 | | | |
| **Дүн** | **8** | **2** | **6** | **-** | **2** | | **-** | **-** |

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn